



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 31 өдөр

Дугаар 4/71

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Т

Монгол Улсын Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 12, 13, 17 дугаар зүйл, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах тухай журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, МУИС-ийн эзэмшдэг барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээг 2 дугаар хавсралтаар, барааны тэмдэг ашиглах хүсэлт гаргах маягыг 3, 4 дүгээр хавсралтаар, гэрээний загварыг 5 дугаар хавсралтаар тус тус баталж 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.
2. Журмыг нийт багш ажилтан, суралцагчдад танилцуулан үйл ажиллагаандаа мөрдүүлэн хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал /Ж.Батхүү/, Эрдэм шинжилгээ инновацийн хэлтсийн мэргэжилтэн /Д.Батхуяг/ нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Д-р А. ГАЛТБАЯР

МУИС-ИЙН БАРААНЫ ТЭМДГИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ЖУРАМ

Нэгдүгээр зүйл. Зорилго

1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Их Сургууль (цаашид “МУИС” гэх)-ийн “Оюуны өмчийн бодлого”-ын дагуу МУИС нь дангаараа эсхүл хамтран эзэмшигчээр эзэмшдэг барааны тэмдгийг ашиглах, ашиглуулах эрхийн хамгаалалт хийх талаарх харилцааг зохицуулахад оршино.
2. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудлыг “МУИС-ийн Оюуны өмчийн бодлого”, “Технологи дамжуулах журам”-аар зохицуулна.

Хоёрдугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

3. Энэхүү журамд нэр томъёог дараах утгаар ойлгоно.

3.1. “Барааны тэмдэг” гэж Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3.1.1-д заасан “иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг”;

3.2. “Бүртгэгдсэн барааны тэмдэг” гэж Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн барааны тэмдгийг,

3.3. “МУИС-ийн нэгж” гэж МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, лабораторийг,

3.4. “ТДТ” гэж МУИС-ийн Технологи дамжуулах төвийг,

3.5. “МУИС-ийн барааны тэмдэг” гэж МУИС-ийн ашиглаж байгаа болон ашиглахаар төлөвлөсөн барааны тэмдгийг,


3.6. “МУИС-ийн нэгжийн хариуцсан барааны тэмдэг” гэж МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, лаборатори нь өөрсдийн бараа, үйлчилгээнд ашиглах барааны тэмдгийг хэлнэ.

3.7. “Гэрээлэгч” гэж МУИС болон МУИС-ийн нэгжийн барааны тэмдгийг ашиглах зөвшөөрөл авч, лицензийн гэрээ байгуулсан этгээдийг хэлнэ.

Гуравдугаар зүйл. Барааны тэмдэг ашиглах тухай

4. МУИС, МУИС-ийн нэгж нь өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа,

үйлчилгээнээс ялгах зорилгоор барааны тэмдэг ашиглаж болно.



5. МУИС нь ашиглаж байсан, ашиглаж байгаа эсхүл ашиглахаар төлөвлөж буй барааны тэмдгийг эрхийн хамгаалалт хийлгэхийн тулд дотоод, гадаадын эрх бүхий байгууллагад бүртгүүлж болно.

6. МУИС-ийн судлаач, ажилтан нь судалгааны үр дүнг илэрхийлэх барааны тэмдэг ашиглаж болно. Энэ нь бусад барааны тэмдгээс ялгагдах байдалтай байна. Үүнийг тухайн судлаач, ажилтны харьяалах МУИС-ийн нэгж ТДТ-тэй зөвшилцэж шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр зүйл. Хэрэглэх байдал, хэлбэр

7. МУИС-ийн барааны тэмдгийг тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд ашгийн бус зорилгоор ашиглана.

8. МУИС-ийн барааны тэмдгийг МУИС-ийн харьяны бус этгээдэд ашиглуулах тохиолдолд төлбөртэй ашиглуулах бодлого барина.

9. "МУИС-ийн Оюуны өмчийн бодлого"-д нийцүүлэн барааны тэмдгийг ашиглах зорилго, хэлбэр, хүрээг барааны тэмдэг тус бүрээр нь тухайн барааны тэмдгийг хариуцсан нэгж гаргаж болно.

Тавдугаар зүйл. Барааны тэмдэгт зохицуулалт хийх нэгж

10. МУИС-ийн барааны тэмдэгтэй холбоотой үйл ажиллагааг хариуцаж ажиллах, зохицуулалт хийх нэгж нь МУИС-ийн ТДТ байна.

11. ТДТ дараах эрх үүргийг хүлээнэ. Үүнд:

11.1. Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт хийх, хүчинтэй хугацааны сунгалт хийх

11.2. Барааны тэмдгийн зөв зохистой ашиглалтад хяналт тавих


11.3. МУИС-ийн нэр дээр бүртгэгдсэн Барааны тэмдгийг ашиглах зөвшөөрөл олгох эсэх

11.4. Барааны тэмдгийг ашиглуулах лицензийн гэрээг байгуулах

11.5. МУИС-ийн нэр дээр бүртгэгдсэн Барааны тэмдгийг ашиглах гэрээнд хяналт тавих

11.6. Барааны тэмдэгтэй холбоотой гарсан маргаан, зөрчлийг шийдэхэд МУИС-ийг төлөөлэх

11.7. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуульчидтай харьцах



12. МУИС-ийн нэгж нь барааны тэмдэг ашиглах хүсэлтээ ТДТ-д бичгээр мэдэгдэнэ.

13. МУИС-ийн нэгж нь өөрийн бараа, үйлчилгээнд ашиглах барааны тэмдгийг зөвхөн МУИС-ийн нэр дээр бүртгүүлнэ.

14. Энэ журмын зүйл, заалтыг зөвшөөрсөн тохиолдолд хувь хүн, хуулийн этгээд нь МУИС-ийн Барааны тэмдэг ашиглах хүсэлтийг гаргаж болно. Хүсэлт хүлээн авснаас хойш ТДТ нь 1 сарын дотор шийдвэрлэж хариу өгнө.

Долоодугаар зүйл. Барааны тэмдгийг бүртгүүлэх

15. ТДТ нь МУИС-ийн барааны тэмдгийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, бүртгүүлсэн барааны тэмдгийн эрхийг сунгуулах, шилжүүлэх, барааны тэмдэгт өөрчлөлт оруулах зэрэг холбогдох үйл ажиллагааг хариуцан ажиллана.

16. Барааны тэмдгийг бүртгүүлэх, сунгуулах, шилжүүлэх, болон өөрчлөлт оруулахтай холбогдон тарах зардлыг тухайн барааны тэмдгийг ашиглах нэгж, этгээд гаргана.

17. МУИС-ийн нэгж нь ашигладаг барааны тэмдгээ сунгуулах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд, энэ тухайгаа бичгээр ТДТ-д мэдэгдэнэ.

Наймдугаар зүйл. Бүртгүүлсэн барааны тэмдгийг нийтэд мэдээлэх

18. МУИС-ийн ТДТ нь эрхийн хамгаалалт хийгдсэн барааны тэмдгийг нийтэд болон холбогдох этгээдэд мэдээлнэ.

Есдүгээр зүйл. Барааны тэмдэг ашиглах тухай зөвшөөрөл олгох

19. МУИС-ийн барааны тэмдгийг ашиглахыг хүссэн этгээдийн зохих заавар, маягтын дагуу гаргасан хүсэлтийг ТДТ хүлээн авч, зөвшөөрөл олгох эсэх тухай анхан шатны дүгнэлт гаргана. (Хавсралт 2, ба 3)

20. Оюуны өмчийн бодлого, Технологи дамжуулах журам ба энэхүү журмыг үндэслэн МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах зөвшөөрлийг хүсэлт гаргагчид өгөх эсэхийг ТДТ-ийн гаргасан дүгнэлтийг үндэслэн Инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал шийдэх бөгөөд татгалзсан тохиолдолд шалтгаанаа хүсэлт гаргагчид тайлбарлан мэдэгдэх үүрэггүй.

21. ТДТ нь барааны тэмдгийг ашиглахыг хүссэн хүсэлтийг хүлээн авч, зөвшөөрвөл гэрээ байгуулж, энэ талаараа холбогдох этгээдэд мэдэгдэнэ.

22. МУИС нь хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд лицензийн гэрээ байгуулах бөгөөд онцгой эрхтэй лиценз олгож, гэрээлэгчийг хамгаалах бодлого баримтлана.

23. МУИС-ийн барааны тэмдэг ашиглах тухай гэрээ байгуулж, төлбөр тооцоогоо хийснээр МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах эрх үүснэ.

УХД0072 9104399

Аравдугаар зүйл. Барааны тэмдэг ашигласны төлбөр

24. МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах этгээд зохих хэмжээний төлбөр төлнө.

Төлбөрийн хэмжээг ТДТ-ийн саналыг үндэслэн МУИС-ийн Захирал батлана.

25. МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээг ашиглах хэлбэр, хүрээнээс хамааран хавсралт №1-д заасны дагуу тогтооно.

26. МУИС-ийн барааны тэмдгийг дараах нөхцөлд ашиглавал төлбөр төлөхгүй.

Үүнд:

26.1. МУИС-ийн албан бичиг, баримт, хэвлэмэл хуудсанд хэрэглэх

26.2. МУИС-ийн багш, ажилтан, суралцагч, гэрээт судлаач нэрийн хуудсандaa ашиглах

26.3. МУИС-ийн албан ёсны вэб хуудас болон түүнтэй адилтгах зүйлд ашиглах

26.4. МУИС-иас эрхлэн гаргаж байгаа албан ёсны танилцуулгад ашиглах

26.5. МУИС дангаараа санхүүжүүлсэн МУИС-ийн дотоод төсөл, түүний үр дүнг ашигийн бус хэлбэрээр ашиглах

26.6. МУИС, МУИС-ийн нэгжээс эрхлэн гаргаж байгаа сурх бичиг, ном, эрдэм шинжилгээний бичгүүдийг төлбөрөөс чөлөөлөх тухай МУИС-ийн Захирлын шийдвэр гарсан бол


27. МУИС-ийн нэгжийн хариуцсан барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээг тухайн нэгж барааны тэмдэг бүрээр гаргаж болно. Ингэж гаргаагүй бол хавсралт 1-д заасан төлбөрийн дагуу тооцно.

28. Барааны тэмдэг ашиглуулснаас орох орлогыг дараах байдлаар хуваарилана. Үүнд:

28.1. "МУИС-ийн барааны тэмдэг"-ийг ашиглуулснаас орсон орлогын 60%-ийг МУИС-ийн төв захиргаа, 40%-ийг ТДТ-д хуваарилана.

28.2. "МУИС-ийн нэгжийн хариуцсан барааны тэмдэг"-ийг ашиглуулснаас орсон орлогын 50%-ийг тухайн нэгжид, 20%-ийг МУИС-ийн төв захиргаа, 30%-ийг ТДТ-д хуваарилана.

Арван нэгдүгээр зүйл. Хяналт тавих талаар



29. МУИС, МУИС-ийн нэгж нь барааны тэмдэг ашиглахдаа холбогдох хууль, дүрэм, журмыг чандлан мөрдөж ажиллана.

30. МУИС, МУИС-ийн нэгж нь хариуцаж байгаа барааны тэмдгийн дотоод ашиглалтад хяналт тавиж ажиллах үүрэг хүлээнэ. Лицензийн гэрээгээр ашиглуулж байгаа барааны тэмдгийн ашиглалтад ТДТ хяналт тавиж ажиллана.

31. МУИС-ийн ТДТ нь МУИС болон МУИС-ийн нэгжид барааны тэмдгийн ашиглалтад холбогдох зөвлөмж болон бусад мэргэжлийн туслалцаа, зөвлөгөөгөөр ханган ажиллана.

32. МУИС-ийн барааны тэмдгийн талаар хувь хүн эсхүл хуулийн этгээдээс ирсэн мэдээллийг МУИС-ийн ТДТ хүлээн авч, зохих арга хэмжээ авна.

33. Барааны тэмдэгийн ашиглалтад зохицуулалт хийх нэгж ТДТ-ийн үйл ажиллагаанд инновацийн асуудал хариуцсан дэд захирал хяналт тавьж ажиллана.

Арван хоёрдугаар зүйл. Гомдол, маргаан, зөрчил шийдэх

34. МУИС-ийн ТДТ нь МУИС-ийн барааны тэмдэгтэй холбогдох гомдол, маргаан, зөрчилд МУИС-ийг төлөөлөн ажиллана. Холбогдох зардлыг тухайн барааны тэмдгийг ашиглах нэгж/этгээд гаргана.

35. МУИС-ийн барааны тэмдгийн эзэмших, ашиглах эрхийг зөрчиж, хууль бусаар ашигласнаас үүсэх зөрчил, хохирлыг хууль, хяналтын байгууллагын тогтоосон буруутай этгээд арилгах үүрэг хүлээх бөгөөд холбогдох зардлыг төлж хохиролгүй болгоно.

36. Энэхүү журамтай холбоотой гарсан гомдол, маргааныг инновацийн асуудал хариуцсан дэд захирал, эсхүл Оюуны өмчийн хороо зохих бодлого, журмын дагуу эцэслэн шийднэ.


37. Барааны тэмдгийг ашиглах, ашиглуулахтай холбогдон гарах аливаа маргаантай асуудлыг оролцогч талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ба тодорхой шийдэлд хүрч чадахгүй тохиолдолд хууль, хяналтын газарт хандаж шийдвэрлүүлнэ.

Арван гуравдугаар зүйл. Бусад

38. МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээг заасан Хавсралт 1-ийг МУИС-ийн ТДТ-ийн саналыг үндэслэн захирлын тушаалаар шинэчлэн

баталгаажуулна.

39. МУИС-ийн Барааны тэмдгийг холбогдох хууль, журам, байгуулсан гэрээг зөрчиж буруу ашигласан бол ашиглагчид өгсөн зөвшөөрлийг хүчингүй болгох, эсвэл ашиглаж байгаа үйл ажиллагааг зогсоож болно. Энэ тохиолдолд өмнө төлсөн төлбөрийг буцаахгүй.



40. Зохих журмын дагуу МУИС-ийн Барааны тэмдгийг ашиглах зөвшөөрөл авснаас бусад этгээд МУИС-ийн барааны тэмдгийг ашиглавал, уг үйл ажиллагааг зогсоож, хохирлыг нэхэмжлэхэд дэмжлэг үзүүлнэ.

41. МУИС-ийн барааны тэмдэг эзэмшигчийн эрхийг зөрчсөнөөс МУИС-д эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд хохирлыг нэхэмжилнэ.

42. МУИС-ийн Барааны тэмдгийг холбогдох хууль, журмыг зөрчин ашигласан, хэрэглэсэн, буруугаар ашигласан, эсхүл зөвшөөрөлгүй ашигласан үйл ажиллагаанаас үүдэн гарсан аливаа хохирлыг МУИС хариуцахгүй.

43. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг ТДТ-ийн саналыг үндэслэн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

ХАВСРАЛТ:

Хавсралт 1 : МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээ

Хавсралт 2 : (Маягт) МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах тухай хүсэлт
(МУИС-ийн дотоод этгээд)

Хавсралт 3 : (Маягт) МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах тухай хүсэлт

(Бусад этгээд)

Хавсралт 4 : (Маягт) МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах тухай гэрээний загвар

Захирлын 2014 оны 03 дугаар сарын 21-ны
өдрийн дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

Хавсралт 1. МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээ

№	МУИС-ийн барааны тэмдэг ашиглах зориулалт	Бүтээгдэхүүний үнийн хувиар 184072 9104399 төлөх		Нэг удаагийн багц төлбөр (төгрөгөөр)		
		Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)	Босго төлбөр (төгрөгөөр)			
1	Хүсэлт гаргах					
1.1	МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах тухай Гэрээ байгуулах хүсэлт гаргах	Хүсэлт бүрд 100 000 ^{*1}				
1.2	МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах Гэрээг сунгуулах хүсэлт гаргах	Хүсэлт бүрд 100 000 ^{*1}				
2	Ашгийн бус зориулалтаар^{*2,*3}					
2.1	Бараа, үйлчилгээнд ашиглах	Борлуулах бол борлуулалтын үнэ эсхүл борлуулахгүй бол нэрлэсэн зардлын 10%.	100 000	1 000 000		
2.2	Хэвлэмэл материалд ашиглах	Борлуулах бол борлуулалтын үнэ эсхүл борлуулахгүй бол нэрлэсэн зардлын 5%.	50 000	500 000		
2.3	Зар сурталчилгаанд ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.				
2.4	Хурал, семинарт ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.				
2.5	МУИС албан ёсоор зохион байгуулах, эсхүл, албан ёсоор оролцох хөтөлбөр, төслийн хүрээнд ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.				
2.6	МУИС-ийн харьяа ашгийн бус сайн дурын нэгдэл (дугуйлан, секц, холбоо, хоршоо, эвлэл) үйл ажиллагаандаа ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.				
3	Ашгийн зориулалтаар^{*2}					
3.1	Бараа, үйлчилгээнд ашиглах	Борлуулалтын үнийн 10%.	150 000	1 500 000		
3.2	Хэвлэмэл материалд ашиглах	Борлуулалтын үнийн 5%.	50 000	500 000		
3.3	Зар сурталчилгаанд ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.				
3.4	Хурал, семинарт ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.				

Анхааруулга:

*1: Гаргасан хүсэлт нь зөвшөөрөгдсөн эсэхээс хамаарахгүй бөгөөд эргэн төлөгдөхгүй,
буцаахгүй, бусад төлбөртэй зөрүү тооцохгүй.

*2: Төлсэн босго төлбөрийг буцаан олгохгүй. Төлбөрийн хэмжээ нь босго төлбөрт
хүрэхгүй тохиолдолд зөрүүг олгохгүй. Гэрээ сунгахад өмнөх зөрүүг бодохгүй.

*3: Ашгийн бус зориулалтаар ашиглаж болох этгээд: ТББ, төрийн байгууллага, ашгийн бус
боловсролын байгууллага.

Захирлын 2014 оны 08 дугаар сарын 31-ны
өдрийн 11 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт

Хавсралт 2 (Маягт) (МУИС-ийн дотоод этгээд)

УХД0672 9104399

**МУИС-ийн Технологи Дамжуулах Төвд
Барааны тэмдэг ашиглах тухай хүсэлт гаргах нь**

Дараах барааны тэмдгийг ашиглах хүсэлтэй байгаа тул хүсэлт гаргав.

Хүсэлт гаргасан _____ нь "МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах тухай журам"-ыг уншиж танилцан, журмын заалт бүрийг зөвшөөрч байна.

Хүсэлт гаргасан:

Овог, нэр	
Харьялагдах байгууллага	
Ашиглах барааны тэмдэг	
Ашиглах зорилго	
Ашиглах хугацаа	
Гарын үсэг	/ /
Огноо	
Төлбөр төлсөн баримт хавсаргасан эсэх	<input type="checkbox"/> Тийм. <input type="checkbox"/> Үгүй.

Зөвшөөрөл

Дээрх хүсэлтийн дагуу МУИС-ийн барааны тэмдэг ашиглахыг

- зөвшөөрөв.
 үл зөвшөөрөв.

Барааны тэмдгийг ашиглах байгууллага/хувь хүн	
Хариуцагч этгээд	
Ашиглах барааны тэмдэг	
Ашиглах зорилго	<input type="checkbox"/> ашгийн бус зорилгоор <input type="checkbox"/> ашгийн зорилгоор
Ашиглах хугацаа	
Гэрээ	
Зөвшөөрөл олгосон этгээд	
Гарын үсэг	
Огноо	

Захирлын 2014 оны 03 дугаар сарын 31-ны
өдрийн 11 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт

Хавсралт 3 (Маягт) (Бусад этгээд)

ИХД0072 9104399

**МУИС-ийн Технологи Дамжуулах Төвл
Барааны тэмдэг ашиглах тухай хүсэлт гаргах нь**

Дараах барааны тэмдгийг ашиглах хүсэлтэй байгаа тул хүсэлт гаргав.

Хүсэлт гаргасан _____ нь "МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах тухай журам"-ыг уншиж танилцан, журмын заалт бүрийг зөвшөөрч байна.

Хүсэлт гаргасан:

Овог, нэр	
Харьялагдах байгууллага	
Ашиглах барааны тэмдэг	
Ашиглах зорилго	
Ашиглах хугацаа	
Гарын үсэг	/ /
Огноо	
Төлбөр төлсөн баримт хавсрласан эсэх	<input type="checkbox"/> Тийм. <input type="checkbox"/> Үгүй.
Гэрээний санал байгаа эсэх	<input type="checkbox"/> Тийм. <input type="checkbox"/> Үгүй.

Зөвшөөрөл

Дээрх хүсэлтийн дагуу МУИС-ийн барааны тэмдэг ашиглахыг

- зөвшөөрөв.
 үл зөвшөөрөв.

Барааны тэмдгийг ашиглах байгууллага/хувь хүн	
Хариуцагч этгээд	
Ашиглах барааны тэмдэг	
Ашиглах зорилго	<input type="checkbox"/> ашгийн бус зорилгоор <input type="checkbox"/> ашгийн зорилгоор
Ашиглах хугацаа	
Гэрээ	
Зөвшөөрөл олгосон этгээд	
Гарын үсэг	
Огноо	

Хавсралт 4 (Гэрээний загвар)

Барааны тэмдэг ашиглуулах гэрээний загвар

МУИС эрхийг нь эзэмшдэг барааны тэмдгийг ашиглуулах гэрээг (цаашид “Гэрээ” гэх) нэг талаас Монгол улсын их сургууль (цаашид “МУИС” гэх), нэгөө талаас (цаашид “Ашиглагч” гэх) нар МУИС-ийн Барааны тэмдгийг ашиглах тухай журмын дагуу дараах нөхцлийг харилцан тохирч байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1. МУИС нь барааны тэмдэгийн (цаашид “Барааны тэмдэг” гэх) оюуны өмчийн бүх эрх буюу эдийн засгийн бүх эрхийг эзэмшигч мөн.

2. Энэхүү гэрээнд МУИС нь барааны тэмдэгийг Ашиглагчид дараах нөхцөлтэй Барааны тэмдэг ашиглах лицензийн эрх олгоно.

2.1. Онцгой эрхтэй/эрхгүй

2.2. Цааш дамжуулах эрхтэй/эрхгүй

2.3. Цуцлах боломжтой

3. Энэхүү гэрээ нь МУИС-ийг бусад этгээдтэй лицензийн гэрээ байгуулахыг хориглох нөхцөл болохгүй.

4. Ашиглагч нь МУИС-ийн Барааны тэмдэгийг ашигласны төлбөрт төгрөгийг дараах хуваарийн дагуу хугацаанд төлнө.

4.1.

4.2.

Хоёр. Барааны тэмдэг ашиглах

5. МУИС нь МУИС-ийн Барааны тэмдэгийн цорын ганц хууль ёсны эзэмшигч нь мөн бөгөөд эдийн засгийн бүх эрхийг эзэмшигч гэдгийг Ашиглагч тал хүлээн зөвшөөрч байна. Ашиглагч нь энэхүү гэрээний 2-д зааснаас бусад хэлбэрээр ямар нэг эрх эдлэхгүй.

6. Ашиглагч нь Барааны тэмдэгийг зөвхөн МУИС-ийн зөвшөөрөл олгосон нөхцөл, хэлбэрийн дагуу гэрээний хүчинтэй хугацааны туршид ашиглах бөгөөд МУИС-ийн нэр хүндэд хохирол учруулахгүй байвал зохино. Ашиглагч нь МУИС-ийн Барааны тэмдэгийн жинхэнэ эрх эзэмшигч гэж өөрийгөө зарлах, эсвэл эрх эзэмшигч нь гэж төөрөгдөл оруулах үйлдвэл хийхийг хатуу хориглоно.

7. Ашиглагч нь Барааны тэмдэгийг ашиглахдаа энэхүү гэрээний нөхцлийг дагаж мөрдөхөөс гадна, МУИС-ийн Барааны тэмдгийг ашиглах тухай журмын зүйл заалтыг хатуу сахиж ажиллана.

8. Энэхүү гэрээний нөхцөл нь гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байж, Ашиглагч нь гэрээний нөхцлийг зөрчөөгүй тохиолдолд Хүртэл үйлчилнэ.

9. Гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссан, Ашиглагч нь гэрээ зөрчсөн тохиолдолд МУИС нь гэрээг нэн даруй цуцлах эрхтэй.

ИХД0072 9104399

Дөрөв. Эрх, үүрэг

10. МУИС нь лиценз олгогчийн хувьд үүрэгтэй

11. Талууд нэг нэгнийхээ өмнөөс гуравдагч этгээдэд учруулсан эдийн болон эдийн бус баялгийн аливаа хариуцлага хүлээхгүй.

12. Ашиглагч нь МУИС-ийн Барааны тэмдгийг чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн/үйлчилгээнд ашиглаж, МУИС-ийн нэр хүндэд хохирол учруулахгүй үйл ажиллагаа явуулна.

13. МУИС нь лицензийн гэрээний хугацаанд Барааны тэмдгийн төлбөр, хураамжийг төлж, хүчинтэй байх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

14. Ашиглагч нь энэхүү гэрээгээр ашиглаж байгаа Барааны тэмдгийг нь гуравдагч этгээд зөрчиж байгаа, эсвэл зөрчих гэж байгаа тохиолдолд МУИС-д мэдэгдэх үүрэгтэй. МУИС нь зөрчлийг арилгуулах арга хэмжээг Ашиглагчтай хамтарч хууль хяналтын газарт мэдэгдэж арилгуулна.

Тав. Бусад

15. Энэхүү гэрээний нөхцөл, заалт бүр нь нууц мэдээлэл бөгөөд байгууллагын болон хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдана. Хууль хяналтын байгууллагын ямар нэг хүсэлтээр энэ гэрээний тухай мэдээллийг задруулах тохиолд талууд нэг нэгэндээ энэ тухай бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

16. Энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд аль болох зөвшилцөх байдлаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв ямар нэг шийдэлд хүрч чадахгүй бол хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

17. Гэрээнд ямар нэг нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтэй бол энэ тухайгаа заавал бичгээр мэдэгдэнэ.

18. Ашиглагч нь цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болж, Барааны тэмдэг ашиглах боломжгүй болсон, төлбөр төлөх чадваргүй болсон тохиолдолд нэн даруй МУИС-д энэ тухайгаа бичгээр мэдэгдэж гэрээг цуцална.

Лиценз олгогч МУИС-ийг төлөөлж

Барааны тэмдэг ашиглагч

Технологи дамжуулах төв

.....